

ГАДААДЫНХАН
МОНГОЛЫН ТУХАЙ

**МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН
ШИНЭЧЛЭЛ БА ГАДААД
ХУДАЛДААНЫ ХЭТИЙН ТӨЛӨВ**

Ким Су Ён*

**(Монгол, БНСУ-ын эрдэмтдийн II
хуралдаанд тавьсан илтгэлийг
товчлон нийтлэв)**

Орос болон Дорнод Европын зарим орны нэгэн адил Монголд ч хэвшмэл, үр ашиггүй социалист эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжихэд чиглэсэн өөрчлөлт шинэчлэлт сүүлийн хэдэн жилд эрчимтэй өрнөж байна. Дээр дурдсан орнуудад тохилдож буй эдийн засгийн шинэчлэлтийн эхний үе шатан дахь үйлдвэрлэлийн хомсдол, өндөр хурдацтай инфляц, гадаад худалдааны тэнцлийн алдагдал зэрэг эдийн засгийн бэрхшээлүүд ч Монголд гарч байна.

Орос, Польш, Унгар зэрэг Дорнод Европын орнууд эдийн засаг, улс төр, газарзүйн байрлалаараа өрнөдийн олон улстай нягт уялдаа холбоотой билээ. Монгол нь Орос, Хятад гэсэн хоёрхон их гүрний дунд байрладаг эх газрын орон учраас тэдгээртэй харьцуулахад бусад улс оронтой улс төр, эдийн засгийн хувьд төдий л өргөн харилцаагүй явж ирсэн юм.

Хүн ам цөөн, орлогын түвшин доогуур учраас зах зээл нь бусад орны сонирхлыг төдийлөн татаж чадахгүй байгаа юм. Түүгээр ч зогсохгүй импорт, экспорт, барилга байгууламж, тоног төхөөрөмж, техник технологи мэтийн гадаад харилцаа нь бараг бүхэлдээ Орост түшиглэсэн байсан учраас өрнөдийнхний анхаарлыг татаж чадахгүй байв.

Гэвч Монгол улс сүүлийн үед дэлхийн эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхитэй оролцохын төлөө хүч чармайлт гаргаж байна.

Тус улс Олон Улсын Валютын Сан, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банкны гишүүн болсон бөгөөд дээрх байгууллагуудаас хөрөнгө мөнгөний болон бусад дэмжлэг туслалцаа авч байна.

Монгол орон арвин их байгалийн баялаг, газар тариалан, мал аж ахуй, харьцангуй өндөр боловсролтой ажиллах хүчиндээ туулгуурлан гадаадаас шууд хөрөнгө оруулж гадаад худалдаагаа өргөтгөхийг эрмэлзэж байна. Мөн НҮБ-ын Хөгжлийн Програмаас эрхлэн явуулж буй Түмэн голын бүс нутгийн хөгжлийн программд идэвхтэй оролцож байна. Монголын шинэчлэлийн болон нээлттэй бодлого амжилттай хэрэгжиж эхлэх юм бол Орос, Хятад, Умард Солонгос, БНСУ, Япон гэх мэтийн улстай хамт шинээр бүрэлдэж буй Зүүн хойд Азийн эдийн засгийн бүс нутгийн гишүүн болж эрчимтэй хөгжиж болох юм.

II. Монголын эдийн засгийн шинэчлэл

1. Хувьчлал ба либералчлал.

Монголын улс төр, эдийн засгийн салбар дахь шинэчлэл, нээлттэй бодлого 1986 оноос эхэлсэн юм. 1986 онд Монголын Засгийн газар, зарим нэр төрлийн барааны бөөний үнийг нэмж төлөвлөгөөт эдийн засгийн үед тоо хэмжээ заан үйлдвэрлэдэг байсан барааны нэр төрлийг 30%-иар цөөрүүлсэн байна. Мөн улсын үйлдвэрийн газруудын хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зарим талаар чөлөөтэй болгожээ.

* Соганы Их Сургуулийн эдийн засгийн ухааны доктор, профессор

1987 онд Засгийн газрын байгууллагуудыг цомхотгон цэгцэлж, зарим нэг хэрэглээний барааны жижиглэнгийн үнийг чөлөөтэй болгов.

1988 онд хоршооллын байгууллагууд болон улсын үйлдвэр аж ахуйн газруудад зарим бүтээгдэхүүнээ зах зээл дээр худалдахыг зөвшөөрсөн бөгөөд цэргийн зардлыг багасгах, ахуй үйлчилгээний салбарын зардлыг нэмэгдүүлсэн байна. Бас хувь хүний гадаад валютыг банкинд татан оруулах зорилгор 3:1 байсан арилжааны ханшийг түүнээс хавьгүй илүү ашигтай арилжааны бус ханш 30:1 болгон тогтоосон байна.

1989 оноос малыг хувьчилж, улсын худалдааны нэгдлүүдийн гадаад худалдаан дахь ноёрхлыг устгаж, улсын үйлдвэрийн газруудыг импорт, экспортод бие даан оролцохыг зөвшөөрсөн байна.

Монголын Засгийн газраас явуулсан эдийн засгийн шинэчлэл нь 1990 оноос бүр хурдаа авч эхэлсэн билээ.

1990 он улс төрийн хувьд ихээхэн чухал он болов. Үндсэн хуулиа шинэчлэн анх удаа сөрөг нам оролцсон парламентийн сонгууль болсон юм.

Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжихэд чиглэсэн эдийн засгийн гол гол шинэчлэл нь парламентийн засаглалыг эмхлэн байгуулахаас эхэлсэн гэж хэлж болно. Социалист маягийн захиргаадгалтын эдийн засгийн гол онцлог бол үйлдвэрлэлийн хэрэгсэл улсын өмч бөгөөд нөөц баялагийн хуваарилалтын төлөвлөлтийн үндсэн дээр хийдэгт оршино. Тийм учраас социализмын захиргааны эдийн засгийн тогтолцооноос зах зээлд шилжихэд хувьчлал (Privatisation) ба үнэ чөлөөлөх (Price Liberalisation) гэсэн үндсэн зорилтыг шийдвэрлэх нь чухал ач холбогдолтой билээ.

Үнийг чөлөөлөх нь яагаад тийм чухал ач холбогдолтой юм бэ?

Төвлөрсөн төлөвлөгөөгөөр бус харин зах зээлээр нөөц баялгийг зүй зохистой хуваарилах гэвэл зах зээлийн бодит байдлын талаар мэдээ дохио өгч байх тийм чадвартай үнэ л хамгийн түрүүнд хэрэгтэй юм. Үйлдвэрлэл ба хэрэглэгч нь үнээс шалтгаалж үйлдвэрлэл, хэрэглээ хуримтлал, хөрөнгө оруулалт зэргээ шийддэг билээ.

Гэтэл зах зээлийн үнэ маань бодит байдлыг тусгаж чадахгүй, үнийг засгийн газраас хатуу тогтоосон нөхцөлд зүй зохистой нөөц баялгийн хуваарилалтыг хангаж чадахгүйд хүрнэ.

Хувьчлалыг үндсэндээ 1991 оны 4 сараас эхэлсэн бөгөөд эдүгээ хувьчлагдсан улсын үйлдвэр, аж ахуйн газруудын тоо (хөдөө аж ахуйн хоршооллын байгууллагуудыг оролцуулаад) 2587 хүрч тэднийг үнэлэх үнэлгээ нь 37 млрд төгрөг болсон байна.

Монголын Засгийн газар Дорнод Европын улс орнуудын нэгэн адил ард түмэндээ хөрөнгө оруулалтын эрхийн бичгийг үнэгүй тарааж уг эрхийн бичгээрээ улсын өмчийг үнэ хаялцан авахыг зөвшөөрсөн байна. Мөн үйлдвэрийн газруудыг хувьчлах зорилгоор хөрөнгийн бирж байгуулагдсан бөгөөд 1994 он гэхэд томоохон хэмжээний үйлдвэрийн газруудыг хувьчилж дуусгах зорилт тавьжээ. Харин уул уурхай, түлш эрчим хүч, төмөр зам, нисэх хүчин, холбоо зэрэг том хэмжээний үйлдвэрийн газрууд улсынх хэвээрээ байх бололтой.

Ихэнх социалист улсууд шиг Монголд ч бас эрчим хүч, хүнсний бүтээгдэхүүн, орон сууцны хөлс, капиталын үнэ маш доогуур, хэрэглээний үнэ өндөр байдаг нь жирийн ард иргэдийн амжиргааны үнэ өртгийг доогуур түвшинд байлгаж капитал төвлөрсөн хүнд үйлдвэр голлосон аж үйлдвэрийн бодлогоос зайлсхийж чадаагүйтэй холбоотой юм.

2. Мөнгө санхүүгийн бодлого, гадаад салбар дахь шинэчлэл

Хувьсчлал, үнэ чөлөөлөлтийн хамтаар санхүүгийн бодлого дахь шинэчлэл Монголд өргөн зар хүрээтэй хийгдэж эхэлсэн юм.

1991 оноос өмнө зөвхөн ганц улсын банк гэж байсан бол 1991 оны 5 сараас арилжааны банкууд байгуулагдав. Санхүүгийн бодлогын хувьд зах зээлийн тогтолцоонд нийцхүй, эн тэргүүнд авбал зохих арга хэмжээнүүдийг авч байна.

Урьд өмнө нь засгийн газрын орлогын ихэнх нь улсын үйлдвэрийн газрын ашиг, импортын барааны үнийн зөрүүгээс бүрддэг байсан бол 1991 оны татварын систем дэх шинэчлэлтээр ашгийн татварын оронд аж ахуйн нэгжүүд ба хувь хүний орлогын татварын системийг хэрэглэх болов. Төлөвлөгөө ёсоор бол хувьчлалыг дагаад улсын үйлдвэрийн газруудын жин багасах учраас үйлдвэрийн газрын ашигт түшиглэсэн татаасын орлогын систем нь өөрчлөгдөхөөс өөр арга байсангүй.

Үнийн шинэтгэл нь засгийн газрын нөхөн төлбөрийг эрс хорогдуулах боломжтой болгосон байна. Мөн 1991 оноос хойшхи төгрөгийн ханшны уналт дотоод дахь үнэтэй харьцуулахад экспортын үнийг ихэсгэж экспортын санхүүжилтийг эрс хорогдуулахад хүргэв. Ихэнх хэрэглээний барааны үнийг чөлөөтэй болгож улсын үйлдвэрийн газруудыг хувьчилсан нь үйлдвэрлэгчийн санхүүжилтийн хэмжээг хорогдуулав.

Гадаад харилцаан дахь шинэчлэлийн нэг зорилго бол худалдааны эрх олгох систем ба гадаад өр зээлийн векселийн системийг боловсронгуй болгох асуудал юм. Урьд нь улсын худалдааны нэгдлүүд дангаараа ноёрхож байсан гадаад худалдаанд улсын үйлдвэрийн газрууд төдийгүй хувийн аж ахуйнууд ч оролцох эрхтэй болсон байна.

Орос болон социалист бусад оронд хэтэрхий төвлөрч байсан гадаад худалдаанд өөрчлөлт хийх зорилгоор юуны өмнө Япон, Америк, Солонгос зэрэг улс орнуудтай гэрээ хэлцэл байгуулж гаалийн татвар болон худалдаатай холбоо бүхий олон улсын гэрээ хэлцэлд нэгдэн орсон байна. Урьд нь гадаад валютын орлогоо бүгдийг засгийн газартаа худалддаг байсан бол шинэчлэлтийн дараа хувиараа экспорт эрхлэгчид олсон гадаад валютаа өөртөө авах буюу, эсвэл чөлөөт зах зээл дээр борлуулах бололцоогоор хангагдав. Мөн улсын үйлдвэр аж ахуйн газрууд хийгээд хувиараа аж ахуй эрхлэгчид экспортынхоо заримыг өөртөө эзэмших болов.

Монголын Засгийн газар 1993 оны 6 сард төгрөг, долларын харьцааг чөлөөт хэлбэлзэгч ханшид шилжүүлэв.

1-р хүснэгт

	1987	1988	1989	1990	1991	1992
Цэвэр материаллаг үйлдвэрлэл (NMP)	3,4	4,2	9,7	0,1	-23,6	-15
Дотоодын нийт бүтээгдэхүүн (GDP)	4,5	5,1	4,2	-2,1	-10	-8,5
ДНБ-ны дефлятор	0,2	1,0	-0,1	-0,4	84,6	-
Хэрэглээний үний өсөлт (CPI)	-	-	-	0,0	120,0	325
экспорт	10,3	1,5	-4,0	-44,1	-22,1	5
импорт	2,3	7,3	5,5	-50,6	-43,8	10

Ашигласан материал, Азийн хөгжлийн банк 1991. Дэлхийн банк 1991 Олон улсын эдийн засгийг судлах төв Бүс нутгийн эдийн засаг 1993.

III. Шинэчлэлийн үйл явц ба эдийн засгийн чиг хандлага

Удаан хугацаанд ноёрхосон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг зах

зээлийн тогтолцоонд шилжих явцад эдийн засгийн хямрал, уналт зогсонги байдалтай тулгарах нь зайлшгүй юм. Ялангуяа шинэчлэлийн бодлого улам эрчимтэй явагдахын хэрээр хямрал, улам гүнзгийрдэг. Ийм үзэгдэл Дорнод Европын болон Орос зэрэг улс орнуудад гарсан билээ.

Шинэ тогтолцоон дахь эдийн засгийн үйл ажиллагаа нь жигдрээгүй байхад хуучин тогтолцоог шинэчлэснээс болж үйлдвэрийн хомсдол мөнгөний ханшны бууралт зэрэг үр дагаврууд гарч ирдэг.

Монголын нийт үйлдвэрлэл, мөнгөний ханш, худалдааны сүүлийн үеийн үзүүлэлт нь дээрх 1-р хүснэгтээс харагдаж байна. 1989 он хүртэл 4-5%-ийн өсөлттэй, ихээхэн тогтвортой байсан мөнгөний бүхий монголын эдийн засгийн зогсонги байдал нь гадаад хүчин зүйлтэй ихээхэн холбоотой юм. 1990 он хүртэл Монгол нь Оросоос ихээхэн хэмжээний тусламж авч байснаа 1991 оноос Орос тусламжаа зогсоосон байна. Монголын гадаад худалдааны ихэнх хэсгийг зээлдэг ЭЗХТЗ-ийн орнуудтай хийдэг байсан худалдаа 1991 онд тус байгууллага татан буугдсанаар эрс буурав. Экспорт буурч Оросын тусламж зогссоноор импорт ч мөн адил буурахаас өөр зам байсангүй. Түүхий эд, бараа материал өргөн хэрэглээний бараа зэрэг бараг бүх төрлийн зүйлээ гаднаас авдаг байсан учраас Монголын эдийн засаг нь импортын уналтад орсноор гэнэтийн цохилтод өртөх нь дамжиггүй байв.

Импортын бууралт, төгрөгийн ханшны уналт, үнийн өсөлт үнийн либералчлал нь инфляцийн гол шалтгаан болжээ. 1993 онд дотоодын нийт үйлдвэрлэлийн хэмжээ эрс буурч 2% болох төлөвтэй хэдий ч одоохондоо тодорхойгүй байна.

Чех, Унгар, Польш зэрэг Дорнод Европын орнууд 1993 онд шилжилтийн үеийн зогсонги байдлаас гарч өсөлтийнхөө шатанд орох төлөв харагдаж байна. Ялангуяа Польш 1990, 1991 онд дотоодын нийт үйлдвэрлэл нь 11,6%, 7% -иар тус тус буурсан бол 1992 онд 1,0% -иар өсч 1993 онд 2,0 % -иар өсөх төлөвтэй байна.

Инфляц нь 1989, 1990 онд 640%, 250 % байсан бол 1992 онд 44%-иар буурсан байна. Эдгээр улс орнууд дахь үйлдвэрлэлийн хомсдлын гол шалтгаан нь ЭЗХТЗ татан буугдсантай холбоотой юм.

IV. Монголын гадаад худалдааны бүтцийн өөрчлөлт

1. Худалдааны харилцаатай байсан орнууд.

Монголын эдийн засагт худалдаа чухал үүрэгтэй. Монголын импорт ДНБ-ны (GDP) харьцаа нь 1988/89 оныхоор 52 % байсан бөгөөд энэ нь тус оронтой хөгжлөөрөө төстэй бусад буурай хөгжилтэй орон болон социалист эдийн засаг бүхий улсуудтай харьцуулахад их өндөр үзүүлэлт юм.

Монголын эдийн засаг гаднаас хараат байдаг үзүүлэлт өндөр байгаагийн шалтгаан нь дээр үеэс зөвхөн Оростой эдийн засгийн нягт уялдаа холбоотой явж ирсэнтэй холбоотой. Нефть, үндсэн түүхий эд, бараа материал, өргөн хэрэглээний бараа зэргийг Оросоос авдаг хараат байдалтай байлаа. Орос бол урт хугацааны бага хүүтэй зээлийг Монголд өгдөг байсан цорын ганц орон учраас Монголын гадаад худалдааны ихэнхийг Оростой хийсэн худалдаа эзлэх нь аргагүй байсан юм. Газар нутгийн хувьд ч гэсэн Орос, Хятадын харилцаа муудсан 1960 оны эхэн үеэс Хятадаас хөндийрсэн учраас Монголтой худалдаа хийж байсан улсуудаас тус орны экспорт, импортод эзлэх хувийг 2-р хүснэгтэд харуулав. Худалдааны бүтцийн гол онцлог нь дээр дурдсанчлан Орос болон ЭЗХТЗ-ийн орнууд Монголын гадаад худалдааны 90-ээс илүү хувийг эзэлж байсанд оршино.

	1960	1970	1980	1990
экспорт	100,0	100,0	100,0	100,0
Орос	75,9	68,4	79,4	78,3
Чехословак	7,7	7,2	5,6	4,5
Унгар	2,1	2,7	1,9	2,1
Польш	2,6	4,0	2,2	1,7
З. Герман	3,7	5,1	3,3	-
ЭЗХТЗ нийтээрээ	-	93,5	96,5	90,9
Хятад	5,9	2,0	1,0	1,7
Япон	0,0	0,4	0,2	1,2
бусад	2,1	4,1	2,3	6,2
	1960	1970	1980	1990
импорт	100,0	100,0	100,0	100,0
Орос	60,7	80,8	85,8	77,5
Чехословак	5,4	4,1	3,5	3,7
Унгар	1,5	2,1	1,2	2,2
Польш	2,7	2,1	1,1	1,4
З. Герман	4,2	3,8	2,2	-
ЭЗХТЗ нийтээрээ	-	96,9	96,8	87,7
Хятад	22,6	0,8	0,6	2,4
Япон	-	0,4	0,1	1,1
бусад	2,8	1,9	2,5	8,8

(ашигласан материал. Дэлхийн банк х. 121, 126, 127)

2. Гадаад худалдааны бараа таваарын бүтэц.

Монголын экспортын гол бараа нь зэс, молибден зэрэг уул уурхайн түүхий эд, ноос, арьс шир, махан бүтээгдхүүн зэрэг мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн юм. 3-р хүснэгтэд үзүүлсэнчлэн 1980 онд хонины ноос, нэхий зэрэг хүнсний бус түүхий эд экспортын гол бараа байсан бол 1990 онд зэс молибден зэрэг ашигт малтмал экспортын хоёрны нэг орчмыг эзлэх болжээ. Экспортын зориулалттай хэрэглээний барааны голыг хувцас эзэлж байв. Импортын хувьд машин, техник, тээврийн хэрэгсэл зэргийн бүтээгдэхүүн үргэлж 40-өөс илүү хувийг эзэлж, нефть зэрэг түлш эрчим хүчний түүхий эд түүний дараагаар орж байлаа. Хэрэглээний бараа мөн адил импортын 15 % -иас илүү хувийг эзэлж байв.

МОНГОЛЫН ЭКСПОРТ, ИМПОРТЫН БҮТЭЦ, НЭГЖ, ХУВЬ

3-р хүснэгт

	экспорт			импорт		
	1980	1985	1990	1980	1985	1990
машин техник тоног						
төхөөрөмж	0,3	0,2	-	45,5	44,3	46,5
түлш, ашигт малтмал	26,4	42,2	48,1	19,6	25,1	21,1
химийн бүтээгдэхүүн						
бордоо, резин	-	-	0,6	5,1	5,1	4,1
барилгын материал	0,4	0,6	3,9	1,5	1,3	1,5

бусад хүнсний бус зориулалтаар тү/эд хүнсний бүтээгдэхүүний түүхий эд	30,9	24,6	15,5	2,0	2,5	3,0
хүнсний бүтээгдэхүүн бэлэн болсон хэрэглээний бараа	13,4	6,1	5,3	2,4	1,3	0,2
нийт дүн	19,0	9,4	6,6	6,9	5,5	6,9
	9,5	16,0	20,0	17,1	15,1	5,8
	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0

Худалдааны бүтцийн өөрчлөлт.

Орос задарч, ЭЗХТЗ татан буугдсан (1991) явцад болон Монголд өөрт нь эдийн засгийн шинэчлэл явагдсанаар тус улсын гадаад худалдааны харилцаатай улсууд хийгээд бараа таваарын бүтэц ихээхэн хурдацтай өөрчлөгдөх боллоо. Монголын ЭЗХТЗ дахь зах зээл үгүй болж Оросын дэмжлэг туслалцаа зогссоноор цаашдаа олон улсын байгууллага болон өрнөдийн хөгжингүй орнуудаас хөрөнгө, технологи оруулж экспортын зах зээлийг шинээр өргөтгөж байж сая эдийн засгийн хөгжилдөө хэрэгтэй импортын хэрэгцээг хангах шаардлагатай болов.

Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудаас буцалтгүй тусламж, зээл авч буй бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг шинэчлэн батлав. Уг хуульд экспортыг хөхүүлэн дэмжих импортын барааг дотооддоо үйлдвэрлэх, гадаад валют олох зэрэг зорилгоор жуулчлал, өндөр технологитой үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүн болон байгалийн баялагийг олборлон боловсруулах дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг 6 салбарын хөрөнгө оруулалтыг нэн тэргүүний салбар болгон уг салбаруудад 5—10 жилийн татварын хөнгөлөлт үзүүлэх ажээ. Мөн Орос, Хятадтай хиллэдэг бүс нутаг зэрэг 4 газрыг чөлөөт эдийн засгийн бүс болгон 15 жилийн турш орлогын ба гаалийн татвараас чөлөөлж зээл тусламж өгөх зэргээр хөнгөлөлт үзүүлж гадаадын хөрөнгө оруулахаар төлөвлөж буй ажээ.

1990 онд Монголын нийт экспортын 94 % -ийг социалист орнууд эзэлж байсан бол 1991 онд 92% байснаа 1992 онд 77 % болон буурав. Импортын хувьд 1990 онд 92 % байснаа 1991 онд 83 %, 1992 онд 50 % болон багасчээ.

Гэвч иймэрхүү бүтцийн өөрчлөлт нь ЭЗХТЗ-ийн худалдааны гэнэтийн бууралтын хамт бий болсон бөгөөд өрнөдийнхэнтэй хийх худалдааны өсөлтөөсөө илүү ЭЗХТЗ-ийн орнуудтай хийх худалдааны бууралтаас болсон үр дагавар юм.

4. Монгол, БНСУ-ын эдийн засгийн харилцаа.

Монгол, БНСУ-ын худалдаа сүүлийн хэдэн жилд эрс өслөө, 1988 онд БНСУ, Монголын экспорт, импортын нийт дүн 600 мянган ам. доллар байснаа 1990 оны 3-р сард Монгол, Солонгосын хооронд дипломат харилцаа тогтсоноор бараа солилцоо эрс нэмэгдэж (хүснэгтэд үзүүлэв) нийт дүн нь 1990 онд 2 сая 700 мянган ам. доллар, 1992 оны байдлаар БНСУ-аас Монголд гаргасан барааны 42 % -ийг тээврийн зориулалт бүхий төрөл бүрийн машин техник, 28% -ийг резин эдлэл, арьс ширэн бүтээгдэхүүн эзэлж, Монголоос авсан барааны дийлэнхийг амьтны эвэр, ноос зэрэг түүхий эд эзэлж байна.

Монгол, БНСУ 1991 оны 3-р сард худалдаа, хөрөнгө оруулалтыг баталгаажуулах, 1992 оны 4-р сард гаалийн давхар татвараас чөлөөлөх хэлэлцээр тус тус байгуулсан боловч үнэн хэрэг дээрээ 1993 оны 4 сар хүртэл БНСУ-аас Монголд шууд хөрөнгө оруулалт огт хийгдээгүй байна.

СОЛОНГОСООС МОНГОЛТОЙ ХИЙСЭН ХУДАЛДАА (ам. доллараар)

4-р хүснэгт

он, сар	1990	1991	1992	1993(1-5 сар)
экспорт	515	5306	8795	2111
импорт	2191	426	1810	813
нийт дүн	2706	5732	10605	2924

Гэвч цаашдаа ДЭҮ корпорац 14 сая америк долларын өртөг бүхий шилний үйлдвэр барих зорилгоор хамтарсан пүүс болон мөн холбоо харилцааны газар байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд Самсунг пүүс 1 сая америк долларын дүрмийн сантай хамтарсан худалдааны пүүс байгуулахаар тохиролцжээ.

Солонгос нь Монголын эдийн засгийн нээлттэй бодлогод тусламж болгож тариурын үйлдвэр байгуулахад 5 сая 200 мянган америк долларын хөнгөлөлттэй зээл 1992 оны 8 сард олгохоор шийдсэн байна.

Үүнээс гадна бага хэмжээний буцалтгүй тусламж үзүүлсэн бөгөөд Солонгосын олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээр дамжуулан мэргэжил дээшлүүлэх хүмүүсийг урих, мэргэжилтэн явуулах, Солонгосын залуучуудын сайн дурын байгууллагынхныг илгээх зэргээр боловсон хүчнээр тусалсаар байна.

V. Монголын эдийн засгийн хөгжлийн чиг хандлага ба зүүн хойд Азийн эдийн засгийн бүс нутаг

Монгол улсын нутаг дэвсгэр 1 сая 570 мянган ам дөрвөлжин км бөгөөд Солонгосын хойгоос 7 дахин том, хүн ам нь 2 сая 200 мянга юм. Гэвч Монгол нь бусад, буурай хөгжилтэй орнууд шиг ажиллах хүч төвлөрсөн аж үйлдвэрийн бүтээгдхүүний экспортыг өргөтгөх замаар аж үйлдвэрийг хөгжүүлж импортын чадавхийг дээшлүүлэх стратегийн бодлогоо явуулахад тохиромжгүй.

Монголын эдийн засаг нь дээр өгүүлсэнчлэн өргөн хэрэглээний бараа, түүхий эд, материал зэрэг өч төчнөөн нэр төрлийн барааг гаднаас авдаг хараат байдалтай байлаа. Цаашдаа импортын бүтээгдхүүнийг дотооддоо үйлдвэрлэх үйлдвэрлэлийг хөгжүүллээ ч гэсэн хязгаарлагдмал дотоод зах зээлээсээ болоод цөөн тооны салбаруудад л тэр нь бо ломжтой юм. Тийм учраас экспортыг өргөтгөж байж л сая өсөн нэмэгдэж байгаа импортын эрэлтийг хангаж болно.

Гадаад худалдааны тэнцлийн алдагдал нь богино хугацааны зээлээр нөхөгдөж болох боловч урт хугацааны турш импортыг багасгах боломжтой.

Монгол нь газар тариалан, мал аж ахуйд тохирсон өргөн уудам газар нутаг, арвин их байгалийн баялагаа ашиглан экспортыг өргөтгөх хэрэгтэй юм. Гэвч зэс, молибден, нүүрс зэрэгт ашигт малтмалууд нь эрчим хүч, капиталын төвлөрөл шаарддаг учраас юуны өмнө ашигт малтмалын үйлдвэрлэлийг өргөтгөхөд хэрэгтэй боловсруулах үйлдвэр, эрчим хүч, төмөр зам, засмал зам зэрэг барилга байгууламжид гадаадын хөрөнгө оруулалтыг ашиглах хэрэгтэй юм.

Ноолуур, ноос, ноосон хөнжил, цамц зэрэг барааны экспортыг өргөтгөхийн тулд шинэ шинэ тоног төхөөрөмж хэрэгтэйн дээр Монгол улс гадаад худалдаа хийхэд газар зүйн байрлалын хувьд төдий л тохиромжтой бус.

Хятад, Оросыг дайрч өнгөрөхгүйгээр гадаад худалдааны харилцаа тогтоох боломжгүй бөгөөд далайгаар алслагдсан юм. Монголд хам-

гийн ойр Тянжинээс Улаанбаатар хүртэл 1600 км зайтай. Тянжин боомтоор дамжуулан бараа таваарыг зөөх гэвэл холоос гадна бусад янз бүрийн бэрхшээлүүд байдаг байна. Тянжин боомт хүртлэх Хятадын төмөр зам байнгын ачаалал ихтэй учраас тэнд ихэвчлэн саатдаг бөгөөд Монгол, Хятадын төмөр замын өргөний хэмжээ өөр учраас хил дээр ачааг солих хэрэгтэй болдог байна. Энэ мэтээс болж цаг их алддаг, зардал их ордог аж. Тянжинээс гадна оросын төмөр замыг ашиглан Находка юмуу Петербургээр дамжин гадаад руу бараа таваар зөөлөө гэхэд хоорондох зай нь 4650-6450 км болно. Харин Монгол, Оросын төмөр замын хэмжээ ижил учраас ачааг сольж ачих зэргээр ажил удахгүйн дээр төмөр зам болон боомт дээр саатах нь бага тул их хэмжээний олон улсын бараа таваар Оросоор дамждаг юм байна.

Монгол нь далайгаас алслагдсаныхаа тээврийн зардлыг багасгая гэвэл дотоодын төмөр зам, авто засмал, онгоцны буудал зэрэг дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, цаашид хил залгаа Орос, Хятадтай иймэрхүү төрлийн байгууламжуудыг өргөтгөн шинэчлэх хэрэгтэй юм. Энэ бүхнээс Түмэн гол дахь бүс нутгийн хөгжлийн программ нь Монголд нэн чухал ач холбогдолтой гэдгийг ойлгож болно.

НҮБ-ын хөгжлийн программын удирдлагаар 1991 оноос эхэлсэн Түмэн гол бүс нутгийн хөгжлийн талаархи яриа хэлэлцээ нь Умард Солонгос, Хятад, Орос гурвыг дайран өнгөрдөг Түмэн голын цутгаланг өөрчилж зам харилцааны чухал объект болгон энэ бүс нутгийг худалдаа, арилжаа, жуулчдын төв болгох зорилготой юм.

Хятадын зүүн хойт гурван мужийн 100 сая хүн ам, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эд түүнчлэн Оросын алс дорнодын мод, нүүрс зэрэг байгалийн арвин баялаг, 20 сая хүн ам нийлээд юуны өмнө энэ төсөл хэрэгжиж эхлэх л юм бол энэ бүс нутгийн хоорондын харилцаа төдийгүй Солонгос, Японтой хийх худалдааг ч эрс нэмэгдүүлэх боломж гарна.

Мөн Сибирийг хөндлөн гулд дайрсан төмөр замаар дамжин Зүүн далай ба Европтой холбогдож улмаар, жишээ нь Япон-Оросын хоорондох бараа таваарыг тээвэрлэхэд цаг хугацаа, зардлыг ихээхэн хэмнэж болох талтай. Монгол нь өмнөд Солонгостой нэгэн адил Түмэн гол - дайрч гарсан биш боловч уг программд албан ёсны гишүүн болон оролцооор байна. Уг программын дагуу Түмэн гол дахь бүс нутаг хөгжиж Монголтой энэ бүс нутгийг холбосон зам харилцаа барьж байгуулах юм бол Монголын гадаад харилцаа улам бүр өргөжиж гадаадын хөрөнгө оруулалт ба дотоодын үйлдвэрлэл нь хөгжлийн шинэ шатанд гарах болно. Монголын хувьд Орос, Хятад, Солонгос зэрэг зүүн хойд Азийн бүс нутаг нь эдийн засгийн харилцааны хамгийн чухал бүс нутаг байхаас өөр аргагүй юм. Түмэн голын хөгжлийн программ хэрэгжих эсэх нь Монголын экспортын нийлүүлэлтийн чадавхиас шалтгаалах бөгөөд эдүгээ экспортын чадавхийг Монголын газар доорхи байгалийн баялаг тодорхойлж байна.

Гэвч энэхүү баялагийн нөөц, түүнийг олборлох боломжийн талаархи мэдээлэл ихээхэн хомс байна.

Эрэл хайгуул, эдийн засгийн судалгаа хийх, олборлох тээвэрлэх ажлыг хөнгөвчлөх дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг зохих хэмжээгээр хийж байж сая гадаадын капитал оруулах боломжийг нээнэ. Гэвч эрэл хайгуул, гол гол барилга байгууламжинд хөрөнгө нэн даруй хэрэгтэй. Ийм учраас Монголын засгийн газар олон улсын байгууллага болон хөгжилтэй орнуудын тусламж авах зэргээр урт хугацааны зээлийг боломжийн хэрээр авч түүнийхээ үлэмж хэсгийг экспортын чадавхийг дээшлүүлэхэд зориулах хэрэгтэй юм.

Монголын байрлал, байгалийг сайтар ашиглах юм бол эх газрын орон Швейцар шиг жуулчлалыг хөгжүүлж гадаад валют олох боломжтой гэдэг. Гэвч сайхан байгальтай л бол жуулчид цуваад байхгүй бизээ.

Жуулчлал нь төмөр зам, авто зам, агаарын зам, холбоо харилцаа, зочид буудал зэрэг дэд бүтцийн янз бүрийн барилга байгууламжууд иж бүрдэл болж байж хөгждөг билээ.

Энэ мэтийн төрөл бүрийн материалыг гаднаас авахаас өөр аргагүй бөгөөд энэ нь Монголын экспорт, эдийн засаг өсөх тусам нэмэгдэх юм.

VI. Товч дүгнэлт.

Социалист эдийн засгаас салж зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шинэчлэлийн үе шатандаа байгаа Монголын эдийн засаг эдүгээ үйлдвэрлэлийн хомсдол, инфляцийн өсөлт зэрэг бэрхшээлүүдтэй учирсаар байна. Гэвч иймэрхүү бэрхшээлүүдийг шилжилтийн үйл явцад тойрохгүй дайрч гарахаас өөр аргагүй.

Орос болон Дорнод Европын улс орнуудад ч ийм байдал гарсаар байна. Монгол орон Оросын эдийн засгийн хараат орон байсан юм. Оростой хийх худалдаа багасч Оросоос авах капиталын хэмжээ буурснаар Монгол орон ихээхэн хямралд орсон юм. Зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үйл явц дахь эдийн засгийн тогтворжилт ба өсөлтийг хангах ганц зам бол эдийн засгийн шинэчлэлийн тууштай бодлого, гадаад эдийн засгийн харилцааг өргөтгөх явдал юм.

Үйлдвэрийн газруудын хувьчлал, үний либералчлалыг амжилттай хэрэгжүүлснээр зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн өөрчлөлтэд үндэслэсэн хувь хүний хүсэл таашаал ба орлого зэргээс хамаарч баялгийн зүй зохистой хуваарилалт хангагддаг эдийн засгийн тогтолцоог бий болгосноор үйлдвэрлэл хэвийн явагдаж үнэ тогтворжих болно.

Шинэчлэлийн бодлогын чиг хандлага, хурдцад ард түмэн итгэж л байх юм бол төөрөгдлийг багасгаж, урт хугацааны төлөвлөлтийг амжилттай хэрэгжүүлж зах зээлийн хямралыг багасгана.

Эдийн засгийн бүтцийн хувьд ихээхэн хараат байдалтай Монголын эдийн засгийн импортыг хангахын тулд экспорт ба капиталыг тодорхой хэмжээгээр бий болгож байж дотоодын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон мөнгөний ханшны тогтворжилтыг хангах бололцоотой болно.

Тийм учраас Монголын Засгийн газар экспортыг нэмэгдүүлэхийг чармайхын зэрэгцээ олон улсын байгууллага, бусад улс орнуудын засгийн газраас Монголд үзүүлэх тусламж дэмжлэг нэмэгдэх ёстой. Монголын урт хугацааны эдийн засгийн өсөлт нь ихээхэн ирээдүйтэй юм.

Монгол нь ихэнх буурай хөгжилтэй орнуудыг бодвол хүн ам цөөн, өргөн уудам нутагтай, арвин их байгалийн баялагтай, боловсролын дундаж түвшин харьцангуй өндөр юм. Тийм учраас эдийн засгийн Хэвийн өсөлт тавигдаж эхлэх л юм бол нэг хүнд ноогдох орлогын түвшингийн өсөлт буурай хөгжилтэй орнуудаас хавьгүй хурдан байх боломжтой.

Орчуулсан **Ч. Энхбат**